Өлгий сумын хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2024/41/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2024 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг:<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>“Ужим Алтай Аудит” ХХК-ны захирал: Б.Галымбек<br>Утас: 99101563 Цахим хаяг: |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**БӨА-2024/41/НА-СТА-ТШЗ**

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
   4.1 Ерөнхий зүйл
   4.2 Материаллаг байдал
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2024.02.06 № 27

танай ____________ -ны № ____________ -т

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН
21 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ М.НУРГҮЛ
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Өлгий сумын хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **43,219,785.33** | **172,821,668.51** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 16,558,355.33 | 128,227,627.51 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 16,558,355.33 | 128,227,627.51 |
| **3121** | **Төгрөг** | 16,558,355.33 | 128,227,627.51 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 16,558,355.33 | 128,227,627.51 |
| **33** | **АВЛАГА** | - | 547,931.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 547,931.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 26,661,430.00 | 44,046,110.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 26,661,430.00 | 44,046,110.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 50,000.00 | 50,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,125,700.00 | 24,096,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,152,980.00 | 2,036,860.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 7,332,750.00 | 17,862,750.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **63,930,208.00** | **74,157,674.29** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 63,930,208.00 | 74,157,674.29 |
| **392** | **Биет хөрөнгө** | 63,328,874.73 | 72,309,102.06 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 37,858,863.00 | 47,214,863.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (7,565,541.66) | (13,535,947.82) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 35,518,527.48 | 41,518,527.48 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (2,482,974.09) | (2,888,340.60) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 601,333.27 | 1,848,572.23 |
| 39301 | Програм хангамж | 880,000.00 | 2,303,239.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (278,666.73) | (454,666.77) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **107,149,993.33** | **246,979,342.80** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **107,149,993.33** | **246,979,342.80** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 107,149,993.33 | 246,979,342.80 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 107,149,993.33 | 246,979,342.80 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 85,525,941.71 | 107,149,993.33 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 21,624,051.62 | 139,829,349.47 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **107,149,993.33** | **246,979,342.80** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **430,513,300.00** | **712,310,339.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,450,000.00** | **26,029,239.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 26,029,239.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 16,779,239.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 9,250,000.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 5,450,000.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 5,450,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **425,063,300.00** | **686,281,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 401,092,600.00 | 685,781,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 401,092,600.00 | 685,781,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 103,500.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 103,500.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23,867,200.00 | 500,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23,867,200.00 | 500,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **408,889,248.38** | **572,480,989.53** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **408,889,248.38** | **572,480,989.53** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 408,099,493.38 | 568,399,089.53 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 304,882,670.67 | 406,951,189.00 |
| 210101 | Үндсэн цалин | 249,394,693.67 | 305,825,526.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 47,943,477.00 | 81,972,063.00 |
| 210104 | Урамшуулал | 7,544,500.00 | 19,153,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,937,100.00 | 69,716,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,477,300.00 | 47,788,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,115,000.00 | 5,482,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,492,000.00 | 4,385,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 622,900.00 | 1,096,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,229,900.00 | 10,964,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 123,700.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 103,500.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 20,200.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 50,778,300.00 | 72,543,960.00 |
| 210502 | Хоол, хүнс | 50,778,300.00 | 72,543,960.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 747,600.00 | 1,224,467.82 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 747,600.00 | 1,224,467.82 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,630,122.71 | 17,462,572.71 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,578,350.00 | 7,402,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,500,000.00 | 3,507,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 6,551,772.71 | 6,551,772.71 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 789,755.00 | 4,081,900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 4,081,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 4,081,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 789,755.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 789,755.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **21,624,051.62** | **139,829,349.47** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **21,624,051.62** | **139,829,349.47** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Өлгий сумын хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **425,063,300.00** | **686,281,100.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **425,063,300.00** | **686,281,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 401,092,600.00 | 685,781,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 401,092,600.00 | 685,781,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 103,500.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 103,500.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23,867,200.00 | 500,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23,867,200.00 | 500,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **408,504,944.67** | **574,611,827.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **408,504,944.67** | **574,611,827.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **407,715,189.67** | **570,529,927.82** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 304,164,539.67 | 407,499,120.00 |
| 210101 | Үндсэн цалин | 248,676,562.67 | 306,373,457.00 |
| 210102 | Нэмэгдэл | 47,943,477.00 | 81,972,063.00 |
| 210104 | Урамшуулал | 7,544,500.00 | 19,153,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,937,100.00 | 69,716,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,477,300.00 | 47,788,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,115,000.00 | 5,482,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,492,000.00 | 4,385,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 622,900.00 | 1,096,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,229,900.00 | 10,964,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 103,500.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 103,500.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 52,990,850.00 | 71,427,840.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 52,990,850.00 | 71,427,840.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 747,600.00 | 1,224,467.82 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 747,600.00 | 1,224,467.82 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,771,600.00 | 20,161,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,271,600.00 | 16,393,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,500,000.00 | 3,767,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **789,755.00** | **4,081,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 4,081,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 4,081,900.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **16,558,355.33** | **111,669,272.18** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 16,558,355.33 | 111,669,272.18 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 16,558,355.33 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 16,558,355.33 | 128,227,627.51 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | 85,525,941.71 | | 85,525,941.71 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **85,525,941.71** | **0.00** | 85,525,941.71 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 21,624,051.62 | | 21,624,051.62 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **107,149,993.33** | **0.00** | 107,149,993.33 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **107,149,993.33** | **0.00** | 107,149,993.33 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **107,149,993.33** | **0.00** | 107,149,993.33 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 139,829,349.47 | | 139,829,349.47 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **246,979,342.80** | **0.00** | 246,979,342.80 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 16,558,355.33 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 686,281,100.00 | 574,611,827.82 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 686,281,100.00 | 574,611,827.82 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 682,199,200.00 | 570,529,927.82 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 522,912,700.00 | 407,499,120.00 |
| 210101 | Үндсэн цалин | 347,440,800.00 | 306,373,457.00 |
| 210102 | Нэмэгдэл | 156,318,300.00 | 81,972,063.00 |
| 210104 | Урамшуулал | 19,153,600.00 | 19,153,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 69,716,900.00 | 69,716,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,788,600.00 | 47,788,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,482,200.00 | 5,482,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,385,500.00 | 4,385,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,096,400.00 | 1,096,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,964,200.00 | 10,964,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 67,372,500.00 | 71,427,840.00 |
| 210502 | Хоол, хүнс | 67,372,500.00 | 71,427,840.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,256,000.00 | 1,224,467.82 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,256,000.00 | 1,224,467.82 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 20,441,100.00 | 20,161,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,673,200.00 | 16,393,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,767,900.00 | 3,767,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,081,900.00 | 4,081,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,081,900.00 | 4,081,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,081,900.00 | 4,081,900.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 500,000.00 | 686,281,100.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 685,781,100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | 685,781,100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 500,000.00 | 500,000.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 500,000.00 | 500,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 16,558,355.33 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 16,558,355.33 | 128,227,627.51 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 32 | 32 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16 | 16 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 15 | 15 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | - | - |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | - | - |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **32** | **32** |
| 650004 | СЕБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 17 | 17 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 15 | 15 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Байхгүй

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлгий сумын хүүхдийн 21 дүгээр цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд “Хамтын оролцоо үнэлгээний үр дүнд суурилсан цэцэрлэгийн менежментийг сайжруулж,хамрагдалтыг нэмэгдүүлэн,Сургуулийн өмнөх боловсролын чанарт ахиц гаргана.” гэсэн

зорилго, “Багшийн хөгжлийг дэмжих,ажлын байранд хөгжих нөхцөл бололцоогоор хангах сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд  дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн  хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өлгий сумын хүүхдийн 21 дүгээр цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй ба тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон  байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Өлгий сумын Хүүхдийн 21 дүгээр цэцэрлэг нь  2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн  бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 139.3 сая төгрөгөөр буюу 130 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|

| Б | 1 | 2 | 3=2-1 |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 16,558.36 | 128,227.63 | 111,669.27 |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 26,661.43 | 44,046.11 | 17,384.68 |
| Үндсэн хөрөнгө | 63,930.21 | 74,157.67 | 10,227.47 |
| **Нийт хөрөнгө** | **107,149.99** | **246,431.41** | **139,281.42** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 107,149.99 | 246,431.41 | 139,281.42 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **107,149.99** | **246,431.41** | **139,281.42** |

Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 128.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалингийн зардлыг хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын данс 17.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн болон бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой ба тайлант онд 9.3 сая төгрөгийн бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Үндсэн хөрөнгийн данс 10.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд үнэ төлбөргүй 16.8 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна.

Тайлант онд 139.3 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 503.0 сая, нийт зарлагыг 503.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалингийн зардлыг 151.9 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 23.3 сая, хоолны зардлыг 2.7 сая, бусад бараа үйлчилгээний зардлыг 6.1 сая, урсгал шилжүүлгийг 4.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, баталсан байна. Энэ нь 2023 онд төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотой дээд шатны төсвийн захирагч хуваарьт өөрчлөлт оруулж нэмэгдүүлж өгсөн боловч оны эцэст 115.4 сая төгрөгийн цалингийн зардлын хэмнэлт гарсан нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүйг харуулж байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 686.3 сая төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 685.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 0.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 685.8. сая , орон нутгийн төсвөөс 0.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 574.6 сая төгрөг буюу 83.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 111.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр | | | | |
| 1 | Эрүүл мэндийн дэмжих | 1,884.00 | 1,604.50 | -279.50 | 85.16% |
| 2 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 67,372.50 | 71,427.84 | 4,055.34 | 106.02% |
| 3 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 3,924.90 | 3,924.90 | 0.00 | 100.00% |
| 4 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх | 1,884.00 | 1,884.00 | 0.00 | 100.00% |
| 5 | Боловсролын стандарт, сургалт | 446,120.30 | 363,445.59 | -82,674.71 | 81.47% |
| 6 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 164,595.40 | 131,825.00 | -32,770.40 | 80.09% |
| 7 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 500.00 | 500.00 | 0.00 | 100.00% |
| | **Дүн** | **686,281.10** | **574,611.83** | **-111,669.27** | **83.73%** |

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын Хүүхдийн 21 дүгээр цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын 21 дүгээр цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 87.9 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын Хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг

сайжруулах үндсэн үйл ажиллагаа болон шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Ужим Алтай аудит” ХХК-ны захирал бөгөөд аудитор Б.Галымбек гүйцэтгэж, хяналтыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек , дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ужим Алтай Аудит “ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын Хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 408,889.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8,177.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж бараа , ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулах арга хэмжээ авч ажилласан гэж үзэх үндэслэлгүй байна. Тухайлбал: Өмнөх онд нормативт зардал, бараа үйлчилгээний зардлын дансанд үлдсэн 16.6 сая төгрөгийг тайлант онд зарцуулснаар хоолны зардлыг батлагдсан төсвөөс 4.0 сая төгрөгөөр илүү зарцуулсан, жилийн дүнгээр 0.7 сая төгрөгөөр илүү зарцуулсан зөрчил илэрч, зөвлөмж өгөгдсөн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 31 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн.

Алдаа, зөрчил илрээгүй.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 43.2 сая төгрөгийн 17 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75%, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 0% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

*Шийдвэрлэсэн нь*:
Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 43.2 сая төгрөгийн 17 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "...... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэснийг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул зөвлөмж өгөв.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчил илрээгүй.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Өлгий сумын хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 56,426.3 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 12,446.5 мянган төгрөгийн алдааг залруулав.

*Залруулсан алдаа:*

- Алдаа, стандартын заалт, батламж мэдэгдлийг хангахгүй байгаа
- Алдаа, стандартын заалт, батламж мэдэгдлийг хангахгүй байгаа
- Алдаа, стандартын заалт, батламж мэдэгдлийг хангахгүй байгаа

*Залруулаагүй алдаа:*

- Алдаа, стандартын заалт, батламж мэдэгдлийг хангахгүй байгаад ямар зөвлөмж өгсөн
- Алдаа, стандартын заалт, батламж мэдэгдлийг хангахгүй байгаад ямар зөвлөмж өгсөн
- Алдаа, стандартын заалт, батламж мэдэгдлийг хангахгүй байгаад ямар зөвлөмж өгсөн

Аудитаар нийт 43,979.8 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 43,979.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Цэцэрлэгийн хүүхдүүдэд тайлант онд 29000 хүүхэд өдрөөр нийтдээ 72,531.7 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан байна. Хүүхдийн нэг өдрийн хоолны зардалд дунджаар 2524 төгрөг зарцуулж, нэг өдрийн хоолны зардлын норм 2475 төгрөгтэй харьцуулахад өдөрт 49 төгрөг буюу жилийн дүнгээр 756.7 мянган төгрөгийг норматив хэтрүүлж зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын батлагдсан норматив тогтоох тухай" 450 дугаар тогтоолын 1 дэх заалтуудыг зөрчсөн ба “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Хүүхдийн хоолны зардлын батлагдсан нормыг 756.7 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Хотгор хүүхдийн цэцэрлэг нь цалингийн зардлын төсвөөс ажилтнуудад 15.8 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал”-тай нийцээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 43.2 сая төгрөгийн 17 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75%, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 0% байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “...... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Илэрсэн зөрчлийг арилгаж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 07 дугаар сарын 01 -ний өдрийн дотор, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу зөвлөмжийг хүлээн авснаас 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэлэс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант оны үр дүнг зөрүүтэй тайлагнасан. | 1 | 547.9 | | | 1 | 547.9 | 1 | 547.9 | | | | |
| Хоолны зардлын гүйцэтгэлийг 11,898.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 11,898.6 | | | 1 | 11,898.6 | 1 | 11,898.6 | | | | |
| **Дүн** | **2** | **12,446.5** | | | **2** | **12,446.5** | **2** | **12,446.5** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Өлгий сумын хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хоолны батлагдсан нормативыг 756.7 мянган төгрөгөөр хэтрүүлсэн. | 1 | 756.7 | | | | | 1 | 756.7 | | | | |
| Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо холбогдох журмыг зөрчсөн. | 1 | 15,845.8 | | | | | 1 | 15,845.8 | | | | |
| **Дүн** | **2** | **16,602.5** | | | | | **2** | **16,602.5** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төсөв, өмч хөрөнгө зарцуулах 43.2 сая төгрөгийн 17 шийдвэрийг шилэн дансанд байршуулаагүй. | 1 | 43,223.1 | | | | | 1 | 43,223.1 |
| Дүн | **1** | **43,223.1** | | | | | **1** | **43,223.1** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |